



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/75/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Х.Билэгбаяр Утас: 94009818 Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|---|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 3. Аудитын тайлан | 4 |
| 3.1 Ерөнхий зүйл | 4 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 4 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 4 |
| 3.4 Материаллаг байдал | 5 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 5 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 6 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 7 |
| 3.8 Аудитын гол асуудал | 7 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 8 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 8 |
| 4. Аудитын илрүүлэлт | 9 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 9 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 42
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
Н.АЛТАНТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020018

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>155,669,862.89</u> | <u>152,800,096.18</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 155,669,862.89 | 152,800,096.18 |
| 351 | Түүхий эд материал | 117,287,245.79 | 117,772,995.58 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 117,287,245.79 | 117,772,995.58 |
| 354 | Хангамжийн материал | 38,382,617.10 | 35,027,100.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,185,050.00 | 1,364,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,880,855.10 | 18,527,403.10 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,450.00 | 9,450.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,585,162.00 | 3,077,597.50 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,914,100.00 | 11,247,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 808,000.00 | 801,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>627,537,269.95</u> | <u>735,015,549.42</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 627,537,269.95 | 735,015,549.42 |
| 392 | Биет хөрөнгө | 394,333,269.95 | 499,161,549.42 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 378,610,494.27 | 388,610,494.27 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -88,068,546.74 | -97,226,605.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 79,907,573.78 | 79,907,573.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,797,860.95 | -34,424,618.35 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 515,634,236.75 | 289,685,113.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -468,505,753.24 | -136,673,204.48 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,290,207.93 | 9,747,227.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -17,243,344.33 | -4,695,842.66 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,089,000.00 | 16,089,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,582,737.52 | -11,857,587.56 |
| 393 | Биет бус хөрөнгө | 233,204,000.00 | 235,854,000.00 |
| 39301 | Программ хангамж | 5,828,719.00 | 3,686,219.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,828,719.00 | -1,036,219.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 233,204,000.00 | 233,204,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>783,207,132.84</u> | <u>887,815,645.60</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>783,207,132.84</u> | <u>887,815,645.60</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 783,207,132.84 | 887,815,645.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | |
| | | 1,257,432,310.11 | 1,257,432,310.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,257,432,310.11 | 1,257,432,310.11 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -682,805,685.56 | -577,203,987.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -682,805,685.56 | -681,812,500.64 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 104,608,512.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 208,580,508.29 | 207,587,323.37 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>783,207,132.84</u> | <u>887,815,645.60</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,289,344,353.27 | 1,370,454,786.61 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 123,309,080.27 | 153,394,707.61 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 123,309,080.27 | 153,394,707.61 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 123,309,080.27 | 153,394,707.61 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 626,200.00 | 630,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 74,469,717.67 | 126,739,390.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 48,213,162.60 | 26,025,317.61 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,166,035,273.00 | 1,217,060,079.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,138,673,400.00 | 1,192,576,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,138,673,400.00 | 1,192,576,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 27,361,873.00 | 24,483,779.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,800,500.00 | 4,147,348.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,724,473.00 | 14,717,631.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,836,900.00 | 5,618,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,226,355,673.09 | 1,265,846,273.85 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,226,355,673.09 | 1,265,846,273.85 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,183,861,545.09 | 1,162,058,599.85 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 926,181,224.00 | 920,172,910.00 |
| 210101 | Үндсэн цалин | 647,878,724.00 | 642,143,010.00 |
| 210102 | Нэмэгдэл | 250,516,700.00 | 248,244,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,785,800.00 | 29,785,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 116,551,771.00 | 121,376,877.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,544,127.00 | 84,950,195.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,039,472.00 | 9,202,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,319,619.00 | 7,361,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,784,205.00 | 1,805,880.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,864,348.00 | 18,057,002.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,020,753.00 | 30,508,938.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,256,000.00 | 4,604,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,375,018.00 | 25,904,138.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,558,749.15 | 44,121,441.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,514,000.00 | 1,153,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,545,062.50 | 7,033,227.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,143,579.00 | 7,045,016.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 34,217,082.60 | 24,201,503.50 |

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|----------------------|-----------------------|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,139,025.05 | 4,688,494.32 |
| 2105 | Нормативт зардал | 527,175.00 | 520,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 527,175.00 | 520,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,052,400.00 | 3,808,650.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 132,200.00 | 110,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,920,200.00 | 3,698,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,843,500.00 | 3,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 8,843,500.00 | 3,160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,130,440.00 | 7,342,473.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,017,600.00 | 6,313,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,740.00 | 160,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,200.00 | 91,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 701,900.00 | 722,223.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,995,532.94 | 31,047,310.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,746,300.00 | 840,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 318,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,249,232.94 | 29,889,110.53 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,494,128.00 | 103,787,674.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 40,136,942.00 | 100,176,142.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 45,988,860.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,136,942.00 | 53,427,282.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 760,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,357,186.00 | 3,611,532.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,357,186.00 | 3,611,532.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 62,988,680.18 | 104,608,512.76 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 62,988,680.18 | 104,608,512.76 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,252,432,310.11 | 208,635,534.67 | -744,349,000.49 | 716,718,844.29 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 55,026.38 | 55,026.38 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,252,432,310.11 | 208,635,534.67 | -744,293,974.11 | 716,773,870.67 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 62,988,680.18 | 62,988,680.18 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,257,432,310.11 | 208,580,508.29 | -682,805,685.56 | 783,207,132.84 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,257,432,310.11 | 208,580,508.29 | -682,805,685.56 | 783,207,132.84 |

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-----|--|-------------------------|-----------------------|------------------------|----------------|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 993,184.92 | 993,184.92 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,257,432,310.11 | 208,580,508.29 | -681,812,500.64 | 784,200,317.76 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -993,184.92 | 00.00 | -993,184.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 104,608,512.76 | 104,608,512.76 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,257,432,310.11 | 207,587,323.37 | -577,203,987.88 | 887,815,645.60 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,166,661,473.00 | 1,217,690,079.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 626,200.00 | 630,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 626,200.00 | 630,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 626,200.00 | 630,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 626,200.00 | 630,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,166,035,273.00 | 1,217,060,079.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,138,673,400.00 | 1,192,576,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,138,673,400.00 | 1,192,576,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 27,361,873.00 | 24,483,779.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,800,500.00 | 4,147,348.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,724,473.00 | 14,717,631.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,836,900.00 | 5,618,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,166,316,513.00 | 1,207,062,079.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,166,316,513.00 | 1,207,062,079.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,123,822,385.00 | 1,103,274,405.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 926,181,224.00 | 920,172,910.00 |
| 210101 | Үндсэн цалин | 647,878,724.00 | 642,143,010.00 |
| 210102 | Нэмэгдэл | 250,516,700.00 | 248,244,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,785,800.00 | 29,785,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 116,551,771.00 | 121,376,877.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,544,127.00 | 84,950,195.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,039,472.00 | 9,202,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,319,619.00 | 7,361,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,784,205.00 | 1,805,880.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,864,348.00 | 18,057,002.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,556,428.00 | 27,857,938.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,256,000.00 | 4,604,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,910,693.00 | 23,253,138.00 |

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|----------------------|-----------------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,176,747.00 | 17,451,457.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,723,100.00 | 1,351,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,704,458.00 | 6,176,663.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,143,579.00 | 7,045,016.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,605,610.00 | 2,877,978.00 |
| 2105 | Нормативт зардал | 667,375.00 | 520,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 667,375.00 | 520,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,673,500.00 | 4,241,550.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 132,200.00 | 110,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,541,300.00 | 4,131,350.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,843,500.00 | 3,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,843,500.00 | 3,160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,020,440.00 | 7,335,473.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,907,600.00 | 6,306,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,740.00 | 160,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,200.00 | 91,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 701,900.00 | 722,223.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,151,400.00 | 1,158,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,151,400.00 | 840,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 318,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,494,128.00 | 103,787,674.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 40,136,942.00 | 100,176,142.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 45,988,860.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,136,942.00 | 53,427,282.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 760,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,357,186.00 | 3,611,532.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,357,186.00 | 3,611,532.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 344,960.00 | 10,628,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 344,960.00 | 10,628,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 344,960.00 | 10,628,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 344,960.00 | 10,628,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 344,960.00 | 10,628,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -344,960.00 | -10,628,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,193,176,300.00 | 1,189,595,140.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,193,176,300.00 | 1,189,595,140.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,093,112,600.00 | 1,090,178,998.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 920,208,700.00 | 920,172,910.00 |
| 210101 | Үндсэн цалин | 642,178,800.00 | 642,143,010.00 |
| 210102 | Нэмэгдэл | 248,244,100.00 | 248,244,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,785,800.00 | 29,785,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 124,228,200.00 | 121,376,877.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,419,800.00 | 84,950,195.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,202,100.00 | 9,202,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,361,700.00 | 7,361,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,840,400.00 | 1,805,880.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,404,200.00 | 18,057,002.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,868,600.00 | 27,857,938.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,604,800.00 | 4,604,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,260,000.00 | 23,253,138.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,010,400.00 | 8,010,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,088,700.00 | 1,088,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,930,800.00 | 2,930,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,915,900.00 | 2,915,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,075,000.00 | 1,075,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 520,000.00 | 520,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдтэл | 520,000.00 | 520,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,558,200.00 | 1,558,200.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 628,000.00 | 628,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 110,200.00 | 110,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 820,000.00 | 820,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,080,000.00 | 3,080,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,080,000.00 | 3,080,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,480,300.00 | 6,444,473.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,415,900.00 | 5,415,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,500.00 | 160,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 91,000.00 | 91,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 757,900.00 | 722,223.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1158200.00 | 1158200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 840,200.00 | 840,200.00 |

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|---------------|---|------------------|------------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 318,000.00 | 318,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 100063700.00 | 99416142.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 100,063,700.00 | 99,416,142.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,988,900.00 | 45,988,860.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,074,800.00 | 53,427,282.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,193,176,300.00 | 1,189,595,140.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,192,576,300.00 | 1,188,965,140.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,192,576,300.00 | 1,188,965,140.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 600,000.00 | 630,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 630,000.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 78.00 | 78.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 72.00 | 72.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|---|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 24,483,407.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 24,483,407.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 23,723,407.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,441,057.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 263,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,245,863.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,129,116.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,802,978.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,311,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,311,350.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 80,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 891,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 891,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 760000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 760,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 760,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 24483779.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 24,483,779.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,147,348.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,717,631.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,618,800.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10 -ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь "Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөр, заавар, журмын дагуу гүйцэтгэх, мэдээ, мэдээллээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хангадаг" Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллага юмаа.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 1,136.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 18.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 1,265.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.3 сая төгрөг, 80 хувь буюу 20.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13 хувиар буюу 104.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 152.8 сая төгрөг болж 2.9 сая төгрөгөөр буурсан нь 4.7 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 26.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 4.7 сая төгрөгийн бараа материал акталж, үйл ажиллагаандаа 45.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 152.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,020.9 сая төгрөг болж 226.6 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 10.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 126.7 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 364.0 сая төгрөгийн хөрөнгийг данснаас шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант оны эцэст 1,020.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл данс буурч, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэн нь үлдэх өртгийг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 887.8 сая төгрөг болж 104.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 887.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,293.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 1,193.2 төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 100.5 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын зардлуудыг төсөвлөсөн хэмжээнээс бага олгосонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,193.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,192.6 сая төгрөгийн санхүүжилт авч, 0.6 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого олж урсгал үйл ажиллагаанд 1,189.6 сая төгрөгийг зарцуулж 3.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,189.6 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь 3.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 24.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 24.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууийн хэрэгжилт, худалдан авалтын И баримтын хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2021 онд нийт 1,193.2 сая төгрөгийн 76 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 1,193.2 сая төгрөгийн 76 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

- Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 0.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Татварын тодорхойлолтоор 1.5 сая төгрөгийн 7 нэр төрлийн татвар зөрүүтэй, газрын төлбөрийн үлдэгдэл 0.4 сая төгрөг нийт 1.9 сая төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- И баримтгүй 0.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 7.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх", 1.3-т "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| | | /сая төгрөгөөр/ | | | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|------|---------|-----|
| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв | 5 | 10.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 5 | 10.3 | 0.0 | 0.0 |